



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/691

Эрдэнэт

### Г Аймгийн онцгой комиссын Шуурхай штабыг түүний удирдлагын тухай хинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Засгийн газрын 2020 оны 103 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2017 оны 08 дугаар тушаал, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 22 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, шуурхай штабын бүтцийг хоёрдугаар, шуурхай штабт ажиллах бүрэлдэхүүнийг гуравдугаар, шуурхай штабын ажиллах түр журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Шуурхай штабт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын үндсэн ажил, үүргийг зохицуулж, цалин хөлс, урамшуулал, илүү цагийн нэмэгдэл хөлс, хууль, тогтоомжийн дагуу тооцож олгохыг холбогдох байгууллагуудын төсвийн захирагч нарт даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал нарт даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны Шуурхай штаб байгуулах тухай A/691 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.




Аймгийн Засаг даргын 2021 оны 88  
дугаар сарын 31.-ны өдрийн 11:59  
дугаар захирамжийн I хавсралт

## АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Шуурхай штабын дарга: Г.Ганбаатар (Аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
- Шуурхай штабын орлогч Д.Золжаргал (Аймгийн Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа)
- Гишүүд:  
А.Түвшинжаргал (Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан аймгийн Засаг даргын орлогч)  
М.Түмэнжаргал (Аймгийн Засаг даргын орлогч)  
Д.Соёлчхүү (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)  
М.Мөнхбаяр (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)  
Н.Бямбацэцэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)  
Ц.Мөнхцэцэг (Аймгийн Засаг даргын эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх)  
С.Цэрэнсамбуу (Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа)  
М.Очирбат (Тагнуулын ерөнхий газрын Орхон аймаг дахь газрын дарга, дэд хурандаа)  
Г.Жигдэнгомбо (Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга)  
Д.Сүхээ (Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга)  
Ж.Бат-Өлзий (Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)  
О.Ариунгэрэлт (Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга)  
Г.Ядмаа (Аймгийн Авто тээврийн төвийн дарга)  
Б.Баасансүрэн (Баян-Өндөр сумын Засаг дарга)  
Б.Зоригтбаяр (Жаргалант сумын Засаг дарга)  
М.Батмөнх (Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын ерөнхий инженер бөгөөд ерөнхий захирлын нэгдүгээр орлогч)
- Нарийн бичгийн дарга: Ш.Ононтал (Аймгийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад)

Аймгийн Засаг даргын 2021 оны 03  
дугаар сарын 15-ны өдрийн 1-дугаар  
захирамжийн II хавсралт

### АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ШУУРХАЙ ШТАБЫН БУТЭЦ



Аймгийн Засаг даргын 2021 оны 03.  
дугаар сарын 31.-ны өдрийн 11/15  
дугаар захирамжийн III хавсралт

ШУУРХАЙ ШТАБТ АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮН

№	Гүйцэтгэх үүрэг	Нэрс	Байгууллага, албан тушаал
1	Дарга	Г.Ганбаатар	Онцгой байдлын газрын дарга, хурандаа
2	Шуурхай штабын орлогч	Д.Золжаргал	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандаа
3	Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ, тандалт-эрсдэл хариуцсан зөвлөх	Ц.Мөнхцэцэг	Аймгийн Засаг даргын эрүүл мэндийн асуудал хариуцсан зөвлөх
		Л.Уранчимэг	Эрүүл мэндийн газрын тархвар судлалийн зөвлөх
4	Эрдэмтдийн баг	Г.Энхбаяр	ШУТП-ын дэргэдэх эрдэмтдийн зөвлөл
5	Шуурхай штабын нарийн бичгийн дарга	Ш.Ононтал	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах, төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад
Хяналт шалгалтын хэсэг			
6	Багийн ахлагч	Д.Болортунгалаг	Мэргэжлийн хяналтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга
7	Гишүүд	Ц.Батзаяа	Хүний эрхийн комиссын Орхон аймаг дахь салбарын дарга
8		Л.Бат-Ирээдүй	Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахмад
9		С.Газарбаатар	Цагдаагийн газрын Хорооллын цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч
10		Г.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
Хэвлэл, мэдээллийн хэсэг			
11	Багийн ахлагч	В.Цэндхүү	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн төвийн ажилтан
12	Гишүүд	Ө.Наранзаяа	Эрүүл мэндийн газрын мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
13		Б.Золзаяа	Баян-Өндөр сумын Хэвлэл мэдээллийн ажилтан
14		Т.Лхагвацэрэн	Жаргалант сумын Хэвлэл мэдээллийн ажилтан
Ажиллагаа зохицуулалтын баг			
15	Багийн ахлагч	Д.Сүхээ	Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
16	Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ, халдвартын сэргийлэлтийн бүлэг	Б.Уртнасан	Эрүүл мэндийн газрын Яаралтай тусlamж, гамшиг, эмнэлгийн тусlamж үйлчилгээний чанар, эрсдэл хариуцсан мэргэжилтэн
17	Б.Билгүүнээ		Эрүүл мэндийн газрын халдварт судлаач

18		Б.Одонтунгалаг	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
19		Б.Болорцэцэг	Онцгой байдлын газрын ангилалын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
20		Ц.Саранцэцэг	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн Халдвартын тасгийн эрхлэгч
21	Татан авалтын бүлэг	Б.Эрдэнэхүү	Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа
22		Б.Өлзийсайхан	Онцгой байдлын газрын Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, техникийн бэлэн байдал хариуцсан мэргэжилтэн, ахмад
23		Х.Баатарзориг	Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын байцаагч, ахлах дэслэгч
24		Т.Бадамсэрээжид	Авто тээврийн төвийн Тээврийн мэргэжилтэн
25		Ц.Эрдэнэчимэг	Эрдэнэт төмөр замын дарга
26		Г.Батцэцэг	Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын байцаагч
27		О.Оргихбаяр	Мал эмнэлгийн газрын Мал эмнэлгийн лабораторийн эрхлэгч
28		Ш.Өлзийбаяр	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын дарга
29		Т.Энхжаргал	Жаргалант сумын ЗДТГ-ын дарга
30	Орон нутгийн шалган нэвтрүүлэх, хяналтын бүлэг	А.Цолмонхүү	Онцгой байдлын газрын Бүсийн төвийн дүн бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, дэслэгч
31		Б.Батцэнгэл	Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч
32		Т.Амарсанаа	Мэргэжлийн хяналтын газрын, хил, гүний хяналтын хэлтсийн дарга
33		Ц.Ганхуяг	Хүнс хөдөө аж ахуйн газар
34	Иргэний болон ажиллах хүчиний бүртгэл, хяналтын бүлэг	Г.Дөлгөөн	Онцгой байдлын газрын Цацраг химиийн хордлогын асуудал хариуцсан мэргэжилтэн, дэслэгч
35		Б.Батцэцэг	Баян-Өндөр сумын Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн
36		Л.Учрал	Жаргалант сумын Засаг даргын орлогч
Тусгаарлан ажиглах баг			
37	Багийн ахлагч	Б.Эрдэнэбаяр	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, хошууч
38	Төлөвлөлт бүртгэлийн бүлэг	Б.Батцэцэг	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн
39		Г.Итгэл	Эрүүл мэндийн газрын эрүүл мэндийн статистик мэдээллийн мэргэжилтэн
40	Тандалт хариу арга хэмжээний бүлэг	А.Баярхүү	Эрүүл мэндийн газрын Сувилахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

41		Г.Ангар	Эрдэнэт сувилал цогцолборын халдварт судлаач
42		М.Уранчимэг	Медипас эмнэлгийн халдварт судлаач
43		С.Дулмаа-Юмлаа	Эрүүл мэндийн газрын халдварт судлаач
44		Л.Баяржаргал	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн Лабораторийн тасгийн эрхлэгч
45	Эмнэлгийн тусlamж үйлчилгээний бүлэг	С.Энхмаа	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн эмчилгээ, чанарын албаны дарга
46		Б.Хишигжаргал	Эрүүл мэндийн газрын сум, өрх, ахмадын тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
47	Хяналтын бүлэг	Н.Одонхүү	Тагнуулын газрын ажилтан, ахлах дэслэгч
48		А.Бадамжунай	Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасаг, Эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч
49		М.Энхтайван	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Иргэд олон нийттэй харилцах, гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн
Орон нутгийн бус хариуцсан баг			
50	Орон нутгийн үйл ажиллагаа зохицуулах бүлэг	Г.Уртнасан	Хойд бүсийн төв Орхон аймгийн Онцгой байдлын газрын Тасгийн дарга, ахлах дэслэгч
51		Б.Анхзул	Онцгой байдлын газрын ангилалын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг			
52	Багийн ахлагч	О.Батцэнгэл	Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн
53	Дүн шинжилгээний бүлэг	Г.Батцэцэг	Мэргэжлийн хяналтын газар Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч
54		Г.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
55		Ц.Эрдэнэтуюя	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
56		Ц.Соёлчимэг	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээ, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
57		Б.Баяраа	Боловсрол соёл урлагийн газрын Бодлого төлөвлөлт хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
Төлөвлөлтийн баг			
58	Багийн ахлагч	Ш.Ононтал	Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах, төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, ахмад
59		П.Хишгээ	Эрүүл мэндийн газрын Эх, хуухдийн тусlamж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

60	Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийн бүлэг	Г.Энхжаргал	Эрүүл мэндийн газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
61		С.Саруул	Онцгой байдлын газрын Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, дэслэгч
62		Д.Жаргал	Мэргэжлийн хяналтын газрын Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч, хэлтсийн дарга
63		Д.Дашням	Боловсрол соёл урлагийн газрын Сургалт, арга зүй, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн
64	Судалгаа, тайлан мэдээний бүлэг	М.Батжаргал	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхэд, залуучуудын хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн
65		С.Нямцогт	Боловсрол соёл урлагийн газрын статистик, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн
66		Б.Ууганцэцэг	Аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Неец, хангалтын баг			
67	Багийн ахлагч	Д.Золжаргал	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, дэд хурандaa
70		М.Ариун-Эрдэнэ	Эрүүл мэндийн газрын Хүний неецийн мэргэжилтэн
71		О.Анхбаяр	Эрүүл мэндийн газрын Эмийн бодлогын хэрэгжилт, чанар аюулгүй байдал, зохицтой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
72		Л.Галсан сайнхувьт	Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн
73	Хүнс, бараа материалын неецийн бүлэг	Г.Баасансүрэн	Хүнс хөдөө аж ахуйн газрын Захиргаа, аж ахуйн албаны дарга, хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
74		Б.Өлзийбаяр	Онцгой байдлын газрын Ахлах нягтлан бодогч, ахмад
Мэдээллийн технологи, харилцаа холбооны баг			
75	Багийн ахлагч	Н.Гансүх	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн захирал
76	Мэдээллийн технологийн бүлэг	Г.Нэргүйбаатар	Онцгой байдлын газрын Холбоо зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, ахмад
77		Б.Нямхүү	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн IT инженер
78		Ч.Эрдэнэбаяр	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Сүлжээний инженер
79		Ц.Баярбилэг	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Радио холбооны инженер
80		Г.Золбоо	Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн Камер засварын инженер
81		М.Гантөмер	Мэдээлэл холбоо сүлжээ ХХК Орхон аймгийн газар инженер
82		Э.Сүхбат	Мэдээлэл холбоо сүлжээ ХХК Орхон аймгийн газар техникч

83	Харилцаа холбооны бүлэг	З.Бямба-Од	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын Холбоо мэдээлэл технологи автоматжуулалтын цехийн дарга
84		Ц.Батмөнх	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын IT инженер
85		Г.Эрдэнэбат	Орхон аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК-ийн захирал
86		Д.Ядамсүрэн	Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн Төрийн мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн
87	Орон зайн дүн шинжилгээний бүлэг	Ч.Батзаяа	Цагдаагийн газрын Холбоо мэдээллийн инженер, дэслэгч
88		Э.Үүрийнцолмон	Тагнуулын газрын мэдээллийн аюулгүй байдлын ажилтан, ахлах дэслэгч
89		Х.Оюун-Эрдэнэ	Эрүүл мэндийн газрын Мэдээлэл технологи, цахим эрүүл мэнд, байгууллагуудын үйл ажиллагааны автоматжуулалт, сүлжээ хариуцсан мэргэжилтэн
90		М.Төмөрчедөр	Татварын газар хураач-Сүлжээний инженер
91		Б.Биндэр	Улсын бүртгэлийн хэлтсийн Мэдээлэл технологийн ажилтан, архивч
92		Э.Соёлмаа	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Хот байгуулалтын кадастр зураг төсөл магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн
Захиргаа, санхүү, аюулгүй байдлын баг			
93	Багийн ахлагч	Д.Алтанхуяг	Цагдаагийн газрын Захиргааны удирдлагын тасгийн дарга, хошууч
94	Захиргаа, санхүү, аюулгүй байдлын бүлэг	О.Энхбаяр	Санхүү төрийн сангийн хэлтсийн Төсвийн төлөвлөлт, зарлага хариуцсан ахлах мэргэжилтэн
95		Н.Чулуун-Эрдэнэ	Эрүүл мэндийн газрын Салбарын санхүү бүртгэл мэдээлэл, нягтлан бодохын ажилтан
96		Б.Ган-Эрдэнэ	Баян-Өндөр сумын ЗДТГ-ын нягтлан бодогч
97	Бичиг хэрэг, архив, өргөдөл, гомдолын бүлэг	Б.Энхсансар	Онцгой байдлын газрын Бичиг хэрэг, архивын эрхлэгч, ахлагч
98		Д.Чулуунхайч	Гэр бүл, хүүхэд залуучууд хөгжлийн газрын арга зүйч
99		Д.Гансүх	Онцгой байдлын газрын Нягтлан бодогч, ахмад

Аймгийн Засаг даргын 2021 оны 03  
дугаар сарын 31-ны өдрийн 21159  
дугаар захирамжийн IV хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ШУУРХАЙ ШТАБЫН АЖИЛЛАХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Коронавируст халдварт (ковид-19)-ын цар тахал (цаашид "Цар тахал" гэх)-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангах аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб (цаашид "Шуурхай штаб" гэх)-ын үйл ажиллагааг зохицуулах, эрх, үргийг тогтооход оршино.

1.2. Шуурхай штаб нь үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Гамшигаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Коронавируст халдварт (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нелөөллийг бууруулах тухай хууль болон бусад хууль тогтоомж, цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, Олон улсын эрүүл мэндийн дүрэм, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийг мөрдлөг болгож ажиллана.

1.3. Шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүнийг аймгийн Онцгой комиссын дарга, сумын Онцгой комиссын Шуурхай штабын бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг энэхүү журамд нийцүүлэн тухайн шатны Онцгой комиссын дарга батална.

1.4. Шуурхай штаб нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа аймгийн Онцгой комиссын Шуурхай штабын нэр бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг ашиглана.

Хоёр. Шуурхай штабын удирдлага, зохион байгуулалт, бүтэц

2.1. Аймгийн онцгой комиссын дарга Шуурхай штабыг бодлого, стратегийн удирдлагаар хангана.

2.2. Шуурхай штабын өдөр тутмын үйл ажиллагааг Шуурхай штабын дарга удирдан зохион байгуулж, аймгийн Онцгой комиссын орлогч дарга хяналт тавина.

2.3. Шуурхай штаб нь Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн байранд үйл ажиллагааг явуулах бөгөөд ажлын цагийн хуваарийг Шуурхай штабын дарга батална.

2.4. Шуурхай штаб нь хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, аймгийн Онцгой комиссын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийн гаргасан зөвлөмж, эрсдэлийн үнэлгээний дүгнэлт зэргийг харгалзан, аймгийн Онцгой комисстой үйл ажиллагаагаа уялдуулж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, чиглүүлж ажиллана.

2.5. Шуурхай штабын бүрэлдэхүүнд гамшигаас хамгаалах алба, тусгай чиг үүрэг бүхий болон холбогдох төрийн байгууллагын мэргэжлийн, шийдвэр гаргах түвшний албан хаагч, Улаан загалмай хорооны төлөөллийг ажиллуулна.

2.6. Шуурхай штаб нь дарга, орлогч, нарийн бичгийн дарга, хяналт шалгалт хариуцсан хэсэг, хэвлэл мэдээллийн хэсэг, хариу арга хэмжээг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажиллагааг-зохицуулалт, тусгаарлан ажиглалт, орон нутаг, бүсийн зохицуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, төлөвлөлт, нөөц-хангалт, мэдээллийн технологи, харилцаа, холбооны баг, захиргаа-санхүүгийн баг (цаашид "хариу арга хэмжээний багууд гэх")-аас бүрдэнэ.

2.7. Шуурхай штабын даргын дэргэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тандалт, эрсдэлийн асуудал хариуцсан зөвлөх ажиллаж, мэргэжил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлнэ.

2.8. Хариу арга хэмжээг зохион байгуулах багуудад үйл ажиллагааны чиглэлээс хамааран дараах бүлэг ажиллана.

2.8.1. Ажиллагаа-зохицуулалтын багт:

- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, халдвартын сэргийлэлтийн бүлэг
- Татан авалтын бүлэг
- Орон нутгийн шалган нэвтрүүлэх хяналтын бүлэг
- Иргэний болон ажиллах хүчиний бүртгэл, хяналтын бүлэг

**2.8.2. Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах баг**

- Төлөвлөвт, бүртгэлийн бүлэг
- Тандалт, хариу арга хэмжээний бүлэг
- Эмнэлэгийн тусламж, үйлчилгээний бүлэг
- Хяналтын бүлэг

**2.8.3. Орон нутаг, бус хариуцсан баг**

- Орон нутгийн харилцан ажиллагааг зохицуулах бүлэг

**2.8.4. Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг**

- Дүн, шинжилгээний бүлэг

**2.8.5. Төлөвлөлтийн багт:**

- Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийн бүлэг
- Судалгаа, тайлан, мэдээний бүлэг

**2.8.6. Нөөц, хангальтын багт:**

- Эм, эмнэлэгийн хэрэгсэл, хүний нөөцийн бүлэг
- Хүнс, бараа, материалын нөөцийн бүлэг

**2.8.7. Мэдээллийн технологи, харилцаа холбооны багт:**

- Мэдээллийн технологийн бүлэг
- Харилцаа холбооны бүлэг
- Орон зайн дун шинжилгээний бүлэг

**2.8.8. Захиргаа, санхүүгийн багт:**

- Захиргаа, санхүү, аюулгүй байдлын бүлэг
- Бичиг хэрэг, архив, өргөдөл, гомдлын бүлэг

2.9. Хариу арга хэмжээний багууд хоорондоо болон аймгийн Онцгой комисс, Шуурхай штабтай үйл ажиллагаагаа уялдуулж мэдээ, мэдээлэл солилцож ажиллана.

2.10. Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, гарсан шийдвэр, иргэд, олон нийтэд нээлттэй ил тод байна.

2.11. Шуурхай штабын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүний нэр, хариуцсан ажил, холбогдох утсыг erdenet.mn цахим хуудасны хэсэгт байршуулна.

2.12. Шуурхай штабын бүрэлдэхүүний ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч, бүлгийн хүн хүчийг бусад баг, бүлэгт түр ажиллуулах, ажлын цагийн зохицуулалт, зохион байгуулалтын арга хэмжээг Шуурхай штабын дарга авч хэрэгжүүлнэ.

**Гурав. Шуурхай штаб, штабын дарга, орлогч, нарийн бичиг, хяналт шалгалтын болон хэвлэл мэдээллийн хэсгийн эрх, үүрэг**

**3.1. Шуурхай штаб дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

3.1.1. Засгийн газар, Улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, шуурхай зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;

3.1.2. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээг хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн нэхцэл байдалтай уялдуулан эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан төлөвлөж зохион байгуулах;

3.1.3. Эм, эмнэлэгийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, ажиллах хучний нөөцийн судалгааг гаргах, хангальтыг зохион байгуулах;

3.1.4. Улсын онцгой комисс, Гамшгаас хамгаалах улсын алба, аймгийн Онцгой комисс, бусийн төвүүдтэй мэдээ, мэдээлэл солилцох, үйл ажиллагааг уялдуулах;

3.1.5. Халдвартын нэхцэл байдлын эрсдэлийн үнэлгээ хийх;

3.1.6. Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хариу егех арга хэмжээг зохион байгуулах;

3.1.7. Орон нутгаас гаргах, орох албан томилолт, ар гэрийн гачигдал, оршуулгын үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг аймгийн Онцгой комиссын Шуурхай штаб олгоно;

3.1.8. Шуурхай штабын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх.

**3.2. Шуурхай штабын дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:**

3.2.1. Шуурхай штабын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, төлөвлөлт, зохион байгуулалтаар хангах, холбогдох тур журам, заавар батлах;

3.2.2. Хариу арга хэмжээний багуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, баг, бүлгийн гишүүдийг хуваарилах;

3.2.3. Шуурхай штабын бүрэлдэхүүн, бусийн төвийн болон орон нутгийн Шуурхай штабуудад үүрэг, чиглэл өгөх, биелэлтийг хангуулах, хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах:

3.2.4. Халдвартын нөхцөл байдалтай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг аймгийн Онцгой комисст танилцуулах;

3.2.5. Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилтийг аймгийн Онцгой комисст тайлагнах;

3.2.6. Аймгийн Онцгой комиссын дарга, орлогч дарга, гишүүдийг мэдээ мэдээллээр хангах;

3.2.7. Бусад

3.3. Шуурхай штабын орлогч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. Шуурхай штабын даргын өгсөн үүргийн хэрэгжилтийг хангах, хариу арга хэмжээний багуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих;

3.3.2. Хариу арга хэмжээний багуудын үйл ажиллаганы төлөвлөгөө, тайланг хянах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Шуурхай штабын даргыг мэдээллээр хангах;

3.3.3. Халдвартын нөхцөл байдалтай холбогдуулах авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, хариу арга хэмжээний багуудын тавьсан санал, хүсэлт, шийдвэрлэх асуудлыг Шуурхай штабын даргад танилцуулах;

3.3.4. Шуурхай штабын бүрэлдэхүүний ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажил, амралтыг зохицуулах, эрүүл мэндийг хамгаалах, халдвартын дэглэмийг сахиулах;

3.3.5. Аймгийн шийдвэрийн төсөл, Шуурхай штабын тайлан, аймгийн Онцгой комисс болон олон нийтэд хүргэх мэдээ мэдээллийг хянах;

3.3.6. Аймгийн онцгой комисс, иргэд, олон нийтийг цар тахлын нөхцөл байдал, түүний эсрэг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээ, мэдээллээр хангах;

3.3.7. Шуурхай штабын бүрэлдэхүүний сахилга, хариуцлага, цаг ашиглалт, үүрэг гүйцэтгэлтэд хяналт тавих.

3.3.8. Бусад

3.4. Нарийн бичгийн дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

3.4.1. Аймгийн онцгой комиссын шийдвэрийн төсөл боловсруулах, гарсан шийдвэрийн бүртгэлийг хөтлөх, Шуурхай штабын үйл ажиллагааны танилцуулга бэлтгэх;

3.4.2. Шуурхай штабын тайлан, мэдээг нэгтгэх;

3.4.3. Шуурхай штабын дарга, орлогч нарт зохион байгуулалт, хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах;

3.4.4. Улс, аймгийн Онцгой комисст Шуурхай штабын тайлан мэдээг нэгтгэж хүргэх.

3.5. Хяналт шалгалтын хэсэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

3.5.1. Хариу арга хэмжээ авах багуудын ажиллагаанд хяналт, шалгалт хийх, зөрчлийг арилгуулах, заавар, зөвлөмж өгөх;

3.5.2. Штабын үйл ажиллагаанд халдвартын дэглэм сахиулах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх;

3.5.3. Засгийн газар, Улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилт, Шуурхай штаб, төрийн болон хувийн хэвшилийн байгууллагын халдвартын дэглэм сахиулах, хамгааллын үйл ажиллагаанд хяналт тавих, зөрчлийг арилгуулах;

3.5.4. Хяналт шалгалтын үр дүн, тайланг Шуурхай штабын даргад танилцуулах, заавар чиглэл авах;

3.6. Хяналт шалгалтын хэсэг дараах чиглэлээр хяналт, шалгалт зохион байгуулах. Үүнд:

3.6.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, тандалт, шинжилгээний үйл ажиллагаа;

3.6.2. Бусад орон нутгаас иргэдийг татан авах болон шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа:

3.6.3. Тусгаарлан ажиглах байрны нөхцөл байдал, халдварт хамгааллын дэглэм, үүрэг гүйцэтгэж буй албан хаагчдын үйл ажиллагаа:

3.6.4. Шалган нэвтрүүлэх товчоо, хөдөлгөөний хязгаарлалтын үйл ажиллагаа:

3.6.5. Хүнс, бараа материал, эм зэмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэлт, хяналтын байдал:

3.6.6. Байгууллага, аж ахуйн нэгжийн халдварт хамгааллын дэглэм, халдварт гүйцэтгэлийн үйл ажиллагаа:

**3.7. Хэвлэл мэдээллийн хэсэг дараах үүргийг хэрэгжүүлнэ:**

3.7.1. Аймгийн онцгой комисс, Шуурхай штабын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хүргэх:

3.7.2. Мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд ойлгомжтой, товч, тодорхой бэлтгэж нэг сувгаар хүргэх:

3.7.3. Бэлтгэсэн мэдээ, мэдээллийн төслийг Шуурхай штабын орлогчид танилцуулж, үүрэг, чиглэл авах:

3.7.4. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр түгж байгаа мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиодолд залруулга хийх:

3.7.5. Олон нийтийн санаа бодлыг судалж, тандсаны үндсэн дээр мэдээ, мэдээллийг бэлтгэх, түгээх:

3.7.6. Хэвлэлийн бага хурал, цахим хурал зохион байгуулах.

**Дөрөв. Хариу арга хэмжээний багуудын чиг үүрэг**

**4.1. Хариу арга хэмжээний багуудын ахлагч дараах үүргийг хэрэгжүүлнэ.**

4.1.1. Багийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлэх, тайлагнах:

4.1.2. Бүлгүүдийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, үүрэг гүйцэтгэх бэлэх байдлыг хангах, заавар, зөвлөмж өгөх:

4.1.3. Бүлгүүдийн тогтвортой ажиллагааг хангах, гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын хариуцлага, дэг журмыг сахиулах:

4.1.4. Багийн гишүүдийн үйл ажиллагааг явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах, халдварт хамгааллын дэглэмийг сахиулах:

4.1.5. Багийн үйл ажиллагааны талаар Шуурхай штабын дарга, орлогчийг мэдээ, мэдээллээр хангах:

4.1.6. Штабын даргын өгсөн үүрэг, даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг хангах:

4.1.7. Бусад багуудтай мэдээ, мэдээлэл солилцох, харилцан ажиллагааг хангах, дэмжлэг үзүүлэх:

**4.2. Ажиллагаа-зохицуулалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

**-Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, халдвартын сэргийлэлтийн бүлэг**

4.2.1. Халдварт авсан иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зэмнэлгүүдийн бэлэн байдлыг хангуулах:

4.2.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, тоног төхөөрөмжөөр хангах тооцоо хийж, шийдвэрлүүлэх:

4.2.3. Сэжигтэй болон батлагдсан тохиолдоор нас барсан иргэнийг оршуулах бэлтгэлийг хангах, тээвэрлэх, хадгалах, оршуулах талаар орон нутгийн захиргааны болон холбогдох байгууллагуудад чиглэл, зөвлөмж өгөх:

4.2.4. Сэжигтэй, магадлалтай, батлагдсан тохиолдолд ХӨСҮТ-тэй хамтран ажиллах:

4.2.5. Суурин болон хөдөлгөөнт лабораторийн судалгаа, шаардагдах хэрэгсэл, ажиллах хүчиний тооцоо гаргах, бэлэн байдлыг хангуулах, хяналт тавих:

4.2.6 Халдвараас сэргийлэх ариутгал, халдваргүйжүүлэлт хийх объект, хүн хүч, тоног төхөөрөмжийн тооцоо, судалгаа гаргах, халдваргүйжүүлэлт хийх ажлын зохион байгуулалтад хяналт тавих;

4.2.7 Хариу арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмжийн тооцоо, нөөцийн судалгааг гаргах;

4.2.8. Цэргийн анги, хорих анги, хүүхдийн асрамжийн газар зэрэг олон хүнтэй газар, ээлжээр ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагуудад халдварт хамгааллын дэглэм сахиулах талаар, зөвлөмж өгөх, хяналт тавих.

**-Татан авалтын бүлэг:**

4.2.9 Бусад орон нутгаас ирэх иргэдийн өргөдөл, хүсэлтийг он, сар, өдрөөр дарааллын дагуу эрэмбэлэх, хүндэтгэн үзэх шалтгаан, тавигдах шаардлагыг харгалzan татан авах

4.2.10. Тусгай захиалгат нислэгээр ирсэн болон гадаад улсаас ирсэн зарим иргэдийг тусгаарлан ажиглах байранд хуваарилах, тээвэрлэх, байрлуулах ажлыг зохион байгуулах;

4.2.11. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ авах шаардлагатай иргэдийг эрэмбэлэн тусгаарлах, тусlamж үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалтыг хийх;

4.2.12. Тусгаарлан ажиглах байрны нөөц, орон нутагтаа ирэх хүсэлтийг гаргасан иргэдийн тоо, байршлыг харгалzan татан авах хуваарь гаргах, батлуулах, татан авах ажиллагааг зохион байгуулах;

**- Орон нутгийн шалган нэвтрүүлэх, хяналтын бүлэг**

4.2.13. Бусад орон нутгаас авто болон темер замаар орон нутгийн хилээр журмын дагуу шалган нэвтрүүлэх ажиллагааг зохион байгуулах;

4.2.14. Орон нутгийн бүтээн байгуулалтад оролцох инженер, техникийн ажилчдыг нэвтрүүлэх ажиллагааг зохион байгуулах;

4.2.15. Олон улсын болон уул уурхайн бүтээгдэхүүн, экспорт, импортын ачаа тээврийн хэрэгслийг орон нутгийн хилээр нэвтрүүлэх ажиллагааг холбогдох байгууллагатай хамтран журмын дагуу зохион байгуулах;

4.2.16. Орхон аймгийн хилээр нэвтэрсэн зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөний мэдээг нэгтгэх;

**- Иргэний болон ажиллах хүчиний бүртгэл, хяналтын бүлэг**

4.2.17. Халдаварын сэжигтэй болон ойрын хавьтлын иргэд, бусад орон нутгаас татан авах болон тусгаарлагдсан иргэдийн овог, нэр, регистрийг Иргэний бүртгэлийн системээс шалгаж үнэн бодитой эсэхийг шүүж, баталгаажуулах;

4.2.18. Аймгийн хэмжээнд тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан иргэд, үүрэг гүйцэтгэж буй эмч, алба хаагчдын бүртгэлийг хөтлөх, гэрийн ажиглалтанд шилжих жагсаалтыг гаргах

4.2.19. Дэд бүтэц, бүтээн байгуулалтад оролцох гадаадын ажиллах хүчиний бүртгэл, судалгааг нэгтгэх

4.2.20. Бүтээн байгуулалтад оролцох ажиллах хүчиний тээвэрлэлт, тусгаарлалт, халдварт хамгааллын дэглэмийг сахиулахад мэргэжлийн заавар, зөвлөмжөөр хангах.

**4.3. Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.**

**-Төлөөвлөлт, бүртгэлийн хэсэг**

4.3.1. Тусгаарлан ажиглах байрны судалгаа гаргах, зөвшөөрөгдсөн байранд иргэдийг хуваарилах

4.3.2. Гадаад улсаас ирсэн болон ойрын хавьтлаар тусгаарлагдсан иргэдийн тоон болон дэлгэрэнгүй мэдээллийг нэгтгэх, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, мэдээллэх

4.2.3. Тусгаарлагдсан иргэдийн мэдээллийг шалгах

4.3.4. Тусгаарлан ажиглах байранд байгаа шинжилгээнд хамрагдах иргэдийн судалгааг гаргах

4.3.5. Гэрийн ажиглалтанд шилжих иргэдийн мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээллэх

- **Тандалт, хариу арга хэмжээний бүлэг**

4.3.6. Цагдаа, тагнуулын газартай хамтран илрүүлсэн ойрын хавьтлыг тусгаарлах үйл ажиллагаанд нь хяналт тавих, зохицуулах

4.3.7. Эхний болон давтан шинжилгээг авсан шуурхай арга хэмжээний багуудын үйл ажиллагаанд хяналт тавих

4.3.8. Шинжилгээний сорьцыг цаг хугацаанд нь лабораторид хүлээлгэн өгч байгаа мэдээллийг нэгтгэх

4.3.9. Лабораторийн уялдаа холбоог хангах, шинжилгээний хариуг цаг хугацаанд нь гаргах үйл ажиллагаанд хяналт тавих

4.3.10. Иргэдийг тусгаарлан ажиглалтаас гаргах үйл явцад хяналт тавьж зохицуулах

4.3.11. Тусгаарлах байрнаас гарах иргэдийг гэрийн ажиглалтад гаргах зөвшөөрлийг тухай өдрийн 11 цагаас өмнө аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлэх ажлыг зохицуулах

4.3.12. Судалгаа, мэдээллийг нэгтгэж аймгийн Онцгой комиссын Шуурхай штабт хүргүүлэх

- **Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бүлэг**

4.3.13. Резидент эмч нарын нөөцийн судалгааг гаргаж, томилуулах

4.3.14. Архаг хууч өвчтэй, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ нэн шаардлагатай хүмүүсийн судалгааг гаргах

4.3.15. Шаардлагатай иргэнд эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах

- **Хяналтын бүлэг**

4.3.16. Тусгаарлах байр, гэрийн ажиглалтанд байгаа иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих

4.3.17. Тусгаарлан ажиглах байрны хэв журмыг сахиулах, аюулгүй байдлыг хангах, гарсан зөрчлийг таслан зогсоох

4.3.18. Тусгаарлан ажиглах байр, гэр /амрах байр/-ийн эрүүл ахуйн халдварт хамгааллын дэглэмд хяналт тавих

4.3.19. Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах баг нь Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 20 дугаар тушаалаар баталсан "Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам", "Гэр /амрах байр/-т тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.

**4.4. Орон нутаг, бүс хариуцсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.4.1. Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрийг аймгийн Онцгой комиссын шуурхай штабт хэрэгжүүлэх талаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих

4.4.2. Бүсийн төв, аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг шаардлагатай мэдээллээр хангах

4.4.3. Засгийн газар, Улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн орон нутаг дахь хэрэгжилт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар Шуурхай штабын даргыг мэдээллээр хангах

**4.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

4.5.1. Шуурхай штаб, хариу арга хэмжээний багуудын хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэх, түүнд дүн шинжилгээ хийх, санал зөвлөмж боловсруулах

4.5.2. Эрсдэл, тандалтын судалгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн үнэлгээ бүрийн үр дүнг мэдээллийн санд оруулах

4.5.3. Мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичиг, Засгийн газар, Улс, аймгийн онцгой комиссын шийдвэрийн хэрэгжилт, Шуурхай штабын үйл ажиллагаанд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх

4.5.4. Лавлах болон нээлттэй утас, цахим болон цаасаар ирсэн өргөдөл, гомдол, шаардлага зөвлөмжийн шийдвэрлэлтэнд дүн шинжилгээ хийх

#### 4.6. Төлөвлөлтийн баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

##### - Эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлтийн бүлэг

4.6.1. Коронавируст халдварын эрсдэлийн үнэлгээг холбогдох байгууллагуудтай хамтран хийх

4.6.2. Халдварын дотоодын тохиолдол хавьтын байршлын зураглалыг гаргах, түүнд үндэслэн хариу арга хэмжээ зохион байгуулах санал, зөвлөмж боловсруулах

4.6.3. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг тодотгох, шаардлагатай нэмэлт оруулах

4.6.4. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр болон Шуурхай штабын үйл ажиллагаатай холбоотой журам, заавар, зөвлөмж, төлөвлөгөөний төсөл, танилцуулга зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулж батлуулах

##### - Тайлан, судалгаа, дүн шинжилгээний бүлэг

4.6.5. Хариу арга хэмжээний багуудын тайлан мэдээг нэгтгэх

4.6.6. Эрүүл мэндийн газар, Халдвартын тасаг, вирулогийн лабораториос ирүүлсэн мэдээллийг нэгтгэх, Шуурхай штаб, бусад байгууллагуудыг мэдээллээр хангах шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх шаардлагатай тохиолдолд бусад эх сурвалжаас мэдээлэл авах

4.6.7. Амийгийн хүн амын вакцинуулалтын талаарх мэдээ, мэдээллийг хүлээн авах, нэгтгэх

4.6.8. Холбогдох судалгааг гаргах

#### 4.7. Нөөц, хангалтын баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

##### - Эм, эмнэлгийн хэрэгсэл, техник, хүний нөөцийн хэсэг

4.7.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хариу арга хэмжээнд шаардагдах хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл /урвалж, оношуур, халдвартгүйтгэлийн бодис, хувийн хамгаалах хувцас хэрэгсэл гэх мэт/ техник, тоног төхөөрөмжийн судалгаа гаргаж, хэрэгцээг тодорхойлох, нөөцийн зураглал гаргах

4.7.2. Улсын хэмжээний хариу арга хэмжээний чиглэл цар хүрээ, шаардагдах нөөцийг харгалzan стандарт шаардлагад нийцсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангалтыг төлөвлөх

4.7.3. Дайчлагдан ажиллах бие бүрэлдэхүүнийг тооцох, ажиллах заавар, журмаар хангах, сургалтанд хамруулах, хяналт тавих

4.7.4. Эмнэлэг, эмнэлгийн зориулалтаар ашиглах барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүний нөөц зэрэг бүх төрлийн нөөцийг дайчлах стратеги боловсруулах

##### - Хүнс бараа материалын нөөцийн хэсэг

4.7.5. Хүнсний нөөцийн судалгааг гаргах, тухай бүр

4.7.6. Ар тал хангалтын /тээврийн хэрэгсэл, харилцаа холбоо, ус, дулаан хувцас, байр, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, шатах тослох материал, хоол хүнсний хангамж, эмнэлгийн тусламж, санхүү/ талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч нэгтгэх, тодотгох

4.7.7. Гамшгаас хамгаалах улсын албадын хүч хэрэгслийн нөөцийн судалгаа гаргах тодотгох

4.7.8. Эмзэг бүлгийн иргэдийн судалгаа гаргах, шаардлагатай тохиолдолд хүнсний тусламж үзүүлэх төлөвлөлт, тооцоолол хийх, зохион байгуулах

#### **4.8. Мэдээллийн технологи, харилцаа холбооны баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

##### **- Мэдээллийн технологийн бүлэг**

4.8.1. Цар тахалтай тэмцэх зорилгоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны мэдээллийн солилцоо, боловсруулалт, түгээлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх судалгаа хийх, санал боловсруулах

4.8.2. Шуурхай штабын үйл ажиллагаанд ашиглагдаж буй программ болон техник хангамж, интернет болон тусгай сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангах тэдгээрийн хэрэглэгчийн мэдээлэлд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх

4.8.3. Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх зорилгоор хөгжүүлсэн мэдээллийн системүүдийн уялдаа холбоог хангах, мэдээллийг анхдагч эх үүсвэрээс авах, мэдээллийн нэгдсэн урсгалыг бий болгох, боловсруулах, оролцогч талуудыг нэгдсэн мэдээллээр хангах нийтэд мэдээллэх зорилгоор салбар хоорондын уялдааг хангах

4.8.4. Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх зорилгоор төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын мэдээллийн системүүдийн хооронд мэдээллийг шуурхай солилцох боломжийг судлах, санал боловсруулах

4.8.5. Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахалтай тэмцэх зорилгоор төрийн мэдээлэл, халдвартын статистик мэдээллийг нэгдсэн байдлаар мэдээлэх дэд бүтцийг бий болгох

4.8.6. Гэрийн ажиглалтад байгаа иргэдийг хянах "CLIX GPS" системийн хэрэгжилтэд хяналт тавих

##### **- Харилцаа, холбооны бүлэг**

4.8.7. Шуурхай штабын 70359099, БОЭТ-ын 70359666, Ниймийн эрүүл мэндийн төв 70353624, Эрүүл мэндийн газар 70350659 дугаарын утасны дуудлагын мэдээг өдөр бүр нэгтгэж, дүн шинжилгээ хийх

4.8.8. Тусгай дугаарт утас, нээлттэй утсанд ирсэн иргэдийн санал, гомдол, шүүмжлэлийг нэгтгэн дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлэх

4.8.9. Коронавируст халдварт /Ковид-19/-ын цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах

4.8.10. Иргэдэд мэдээлэл өгөх, дуудлага хүлээн авах тусгай дугааруудыг нэгтгэх

##### **- Орон зайн дүн шинжилгээний бүлэг**

4.8.11. Коронавируст халдварт /Ковид-19/-ын нөхцөл байдлын талаарх орон зайн мэдээллийг бүрдүүлж холбогдох мэдээллийн сангудаас цахим хэлбэрээр татан төвлөрүүлж, дүн шинжилгээ хийх, үр дүн, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх

4.8.12. Халдвартын нөхцөл байдлын талаарх мэдээллийг орон зайн мэдээллийн системүүдээр дамжуулан иргэн, хуулийн этгээдэд хүргэх

4.8.13. Коронавируст халдварт /Ковид-19/-ын болон олон улсын хөл хориот бусад халварт өвчний үед орон зайн мэдээллийн системийг ашиглан дүн шинжилгээ хийх, тандалт хийх, бусад байгууллагуудыг мэдээллээр хангах дэд бүтцийг бий болгох санал боловсруулах

#### **4.9. Захиргаа, санхүүгийн баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:**

##### **- Захиргаа, санхүү, аюулгүй байдлын бүлэг**

4.9.1. Шуурхай штабын дотоод ажлыг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах

4.9.2. Хэсэг, багийн ахлагчийн саналаар гишүүдийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх үүднээс ажиллах өдөр, цагийн хуваарийг гаргах

4.9.3. Шуурхай штабын бүрэлдэхүүний ажилласан өдөр, ажилласан өдөр, цагийн тооцоог гаргах, байгууллагуудад хүргүүлэх

4.9.4. Шаардлагатай хүч хэрэгслийг тодорхойлох, татан оролцуулах, сэлгэн ажиллуулах

4.9.5. Тусгаарлан ажиглах байранд тусгаарлагдсан иргэд, үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдын тоо, тусгаарлагдсан хоногийг тулгаж тооцоо нийлэх, тусгаарлах байрны төлбөр тооцоог хариуцсан байгууллагад баталгаажуулан хүргэх

4.9.6. Шуурхай штабын үйл ажиллагааны зардал, төлбөр тооцоог шийдвэрлэх, зохион байгуулах

4.9.7. Шуурхай штабын бүрэлдэхүүний хоол унаа, халдвартгуйжүүлэлт, дархлаажуулалтыг шийдвэрлэх

4.9.8. Хариу арга хэмжээнд шаардлагатай неөцийг бүрдүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх

4.9.9. Багуудын үйл ажиллагааг хэвийн явуулах байр, бичиг хэрэг, техник тоног төхөөрөмжөөр хангах санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлэх

- **Бичиг хэрэг, архив, өргөдөл гомдолын бүлэг**

4.9.10. Штабын үйл ажиллагааг баримтжуулах, хариу арга хэмжээний баг, бүлгүүдээс гарсан тайлан мэдээ, судалгаа, баримт, материалыг архивлах

4.9.11. Өргөдөл гомдолыг хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдээ, мэдээллийг нэгтгэх, Хэвлэл мэдээллийн хэсэг, Мэдээллийн технологи, харилцаа, холбооны багт тогтмол хүргүүлэх

4.9.12. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, бүртгэх, холбогдох багуудад хуваарилах, шийдвэрлэлтийн бүртгэл хөтлөх, эзэн холбогдогчид эргэн мэдэгдэх

#### Тав. Бусад зүйл

5.1 Штабын бүрэлдэхүүн нь төрийн алба хаагчийн ёс зүйг баримтлан авилга ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.

5.2 Штаб нь ажлын тусгай горимоор буюу уртасгасан цагаар ажиллана.

5.3 Штабын бүрэлдэхүүнд ажиллаж байгаа алба хаагчдын илүү цагаар ажилласан цагийн бүртгэлийг үндэслэн холбогдох байгууллагын удирдлага тухайн ажилтанд нэмэгдэл хөлс, шагнал, урамшуулалт олгох асуудлыг шийдвэрлэнэ.

5.4 Энэхүү журмыг зөрчсөн, үүргээ зохих ёсоор биелүүлээгүй албан хаагчид холбогдохм хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох саналыг тухайн алба хаагчийн харьяалах байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлнэ.

\_ОО\_